

## **Банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх арга зам, боломжууд**

### **The Possible Ways to Increase Equity of Banks**

Л. Оюун<sup>1</sup>

Хураангуй

Олон улсын валютын сан (ОУВС)-гаас манай улсад хэрэгжүүлж байгаа “Өргөтгөсөн санхүүжилт”-ийн төслийн хүрээнд банкны салбарын тогтвортой байдалд үнэлэлт дүгнэлт өгч, банкуудын эрсдэлийн удирдлагын аргачлалыг сайжруулах зөвлөмжийг боловсруулах зорилгоор активын чанарын үнэлгээ хийж байна. Үүнд хувь нэмэр болох зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийлээ. Банкны тогтвортой байдлыг хангадаг хамгийн гол хөрөнгө нь өөрийн хөрөнгө бөгөөд бид энэ судалгаагаараа манай улсад үйл ажиллагаагаа явуулж буй 14 арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн өнөөгийн байдалд 2015 оны III улирлын байдлаар үнэлгээ өгөөд зогсохгүй, активын хэмжээгээр нь гурав ангилан, аль банк нь аль хувилбараар өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх боломж байгаа талаар өөрсдийн дүгнэлтийг гаргаж, саналаа дэвшүүллээ.

*Түлхүүр үгс:* банкны тогтвортой байдал, банкны өөрийн хөрөнгө, дүрмийн сан, өөрийн хөрөнгө нэмэгдүүлэх боломж

---

<sup>1</sup> МУИС-ийн Бизнесийн Сургуулийн Санхүүгийн тэнхимийн багш, зөвлөх профессор  
E-mail: sanlavmed@yahoo.com

## Оршил

ОУВС-гаас Монгол Улсад 2017 оноос хэрэгжүүлж байгаа “Өргөтгөсөн санхүүжилт”-ийн төслийн хүрээнд өнөөдөр Монголын арилжааны банкуудад “Активын чанар”-ын үнэлгээ хийж байна. Энэхүү үнэлгээ хийж байгаа зорилго нь банкуудыг актив хөрөнгөө зохистой үнэлж, чанаргүй активын алдагдлаас хамгаалах хангалттай өөрийн хөрөнгөтэй эсэхийг тогтооход чиглэж байна. Энэ ажлын хүрээнд Монголын банкны салбарын тогтвортой байдалд үнэлэлт дүгнэлт өгч, банкуудын эрсдэлийн удирдлагын аргачлалыг сайжруулах зөвлөмжийг боловсруулах зорилготой. Активын үнэлгээг хийлгэснээр үнэлгээнд хамрагдаж буй банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөрийн чадварын үзүүлэлт нь ирээдүйд активын чанар буурч, эрсдэлийн санг нэмэгдэхэд зохистой түвшинд байгаа эсэхийг Монголбанкнаас баталгаажуулах боломж олгох юм.

Нэг. Монгол улсын арилжааны банкны өөрийн хөрөнгийн өнөөгийн байдал

Монгол улсын банкны салбарын өөрийн

хөрөнгийн нэг хэсэг болох дүрмийн сангийн хэмжээ өнгөрсөн хугацаанд өөрчлөгдөж ирсэн.

Хүснэгт №1. Банкны дүрмийн сангийн доод хэмжээ

Он	Дүрмийн сангийн доод хэмжээ, сая төгрөгөөр
1991	50.0
1995	400.0
1999	2,000.0
2001	4,000.0
2006	8,000.0
2011	16,000.0
2015	50,000.0

2017 оны 12-р сарын 31 гэхэд арилжааны банкууд дүрмийн сангаа 50 тэрбум төгрөг болгох ёстой.


2015 оны гуравдугаар улиралд банкны салбарын өөрийн хөрөнгийн хэмжээ 2.4 их наяд хүрч өмнөх оны мөн үеэс 26.3 хувиар буюу 502 тэрбум төгрөгөөр, эрсдэлээр жигнэсэн активын хэмжээ 12.9 их наяд хүрч өмнөх оны мөн үеэс 20 хувиар буюу 3.2 их наяд төгрөгөөр буурсан байна. Банкны салбарын өөрийн хөрөнгө 2010 оноос хойш 2015 оны III улирлыг хүртэл дараах хэмжээтэй байна.

Зураг 1. Монгол улсын арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн хэмжээ



Эх сурвалж: Монголбанк, Банкуудын нэгдсэн тайлан, 2015 оны III улирал, мянган төгрөгөөр

Зураг 2. Арилжааны банкуудын дүрмийн сангийн хэмжээ




Эх сурвалж: Арилжааны банкуудын тайлан, 2015 оны III улирал, мянган төгрөгөөр

Дээрхээс харахад 2015 оны гуравдугаар улирлын байдлаар дүрмийн сангийн доод хэмжээг 2011 онд 16 тэрбум төгрөг болгож өсгөсөн шаардлагыг бүх банкууд хангаж байгаа ч 2015 онд батлагдсан заавал байлгах нөөцийн доод хэмжээг 50 тэрбум болгох шаардлагыг хангаж буй банкууд Төрийн банк болон Голомт банкууд байна. Харин бусад банкуудын хувьд 10 тэрбумаас 34 тэрбум төгрөг хүртэл нэмэлт өөрийн хөрөнгө шаардлагатай болж байгаа юм.

Арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн хэмжээ 2015 оны гуравдугаар улиралд 2.4 их наяд хүрсэн бөгөөд банкуудын өөрийн хөрөнгийн хэмжээ жил ирэх бүр нэмэгдэж байгаа ч өсөлтийн түвшин улирал бүр буурах хандлагатай байна.

2015 оны гуравдугаар улирлын байдлаар арилжааны банкны өөрийн хөрөнгө системийн хэмжээнд банкууд тус бүрийн өөрийн хөрөнгө болон эзлэх хувь дараах байдалтай байна.

Зураг 3. Арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн эзлэх хувь, хэмжээ




Эх сурвалж: Банкуудын санхүүгийн тайлан, 2015 оны III улирал

Монголд үйл ажиллагаа явуулж буй банкуудаас ХААН банк, Худалдаа хөгжлийн банк нийт банкны системийн өөрийн хөрөнгийн 73 хувийг, Хас банк,

Төрийн банк, Улаанбаатар хотын банк, Капитрон банкууд 23 хувийг, үлдсэн хувийг жижиг банкууд эзэлж байна. Эдгээр банкуудын өөрийн хөрөнгийн бүтцийг

Зураг 4. Банкуудын өөрийн хөрөнгийн бүтэц



Эх сурвалж: Банкуудын санхүүгийн тайлан, 2015 оны III улирал

харуулвал:

2015 оны гуравдугаар улирлын байдлаар банкуудын өөрийн хөрөнгөө бүрдүүлж байгаа хөрөнгүүд дээрх байдалтай байна. Үүнд:

- ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хас банк, Улаанбаатар хотын банкуудын өөрийн хөрөнгийн 58-67 хувийг хуримтлагдсан ашиг эзэлж байгаа нь активын хэмжээ их банкууд өөрийн хөрөнгөө хуримтлагдсан ашгаар бүрдүүлдэг нь харагдаж байна. Хуримтлагдсан ашигтаа өмнөх үеийн ашиг нь дийлэнхи хувийг бүрдүүлж байна.
- Дээрх 5 банкуудаас бусад банкуудын хувьд өөрийн хөрөнгийн 46-213 хүртэл хувийг энгийн хувьцаа бүрдүүлж байна. Эдгээр банкуудаас Чингис хаан банк, Капитрон банк, Ариг банк, Кредит банк, Тээвэр хөгжлийн банкууд тайлант үед болон өмнөх үед (2014 оны жилийн

эцсийн байдлаар) алдагдалтай ажиллаж, хувьцаат капиталыг ихээр нэмэгдүүлсэн байна.

Дээрхээс Монголын арилжааны банкууд өөрийн хөрөнгөө энгийн хувьцаа болон хуримтлагдсан ашгаараа голлон бүрдүүлдэг болох нь харагдаж байна. Энгийн хувьцаа болон хуримтлагдсан ашгаас гадна Голомт банкны 16.9 хувийг, Капиталын банкны 27.7 хувийг хоёрдогч өглөг, Худалдаа хөгжлийн банкны 21.0 хувийг, ҮХО-ын банкны 32.0 хувийг дахин үнэлгээний сан бүрдүүлж байна.

Арилжааны банкуудын 2015.09.30-ны байдлаарх нийт банкны системд эзлэх активын хэмжээ болон Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцох журмын дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээний хувь хэмжээг (Хүснэгт 3)-т харуулав.

Банкуудаа активын хэмжээгээр нь том,

## Хүснэгт 2. Монгол банкнаас тогтоож буй өөрийн хөрөнгийн шаардлага

Огноо	2012.06.30	2012.12.31	2013.06.30	ОУ-ын стандарт (Базелийн хороо)
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	≥7%	≥8%	≥9%	≥4%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	≥12%	≥12%	≥12%	≥8%
Нэмэлт өөрийн хөрөнгийн шаардлага*	0.5%	1.0%	2.0%	
Нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	≥12.5%	≥13.0%	≥14.0%	

\* - Сүүлийн 6 сар банкны системийн нийт активын 5 хувиас дээш хувийг бүрдүүлж байгаа банкуудад нэмэлт өөрийн хөрөнгө тооцно.

## Хүснэгт 3. Арилжааны банкуудын системд эзлэх хувь болон өөрийн хөрөнгийн хүрэлцээний хувь хэмжээ

	Нийт системд эзлэх хувь	Активын хэмжээ (мян.төг)	НЗӨХ/ЭЖА	ӨХ/ЭЖА	ТТГЧ
ХХБ	26.6%	5,482,283,922.0	11.78%	16.43%	41.57%
ХААН банк	24.6%				
Голомт банк	16.6%				
Төрийн банк	9.5%	1,948,541,053.0		15.30%	35.70%
Хас банк	8.4%				
УБХБанк	6.5%				
Капитал банк	4.1%	841,806,868.3			
Чингис хаан банк	1.1%				
ҮХОБанк	1.0%				
Капитрон банк	0.8%	174,518,813.0	13.43%	16.13%	37.43%
Ариг банк	0.4%				
Богд банк	0.2%				
Кредит банк	0.1%	39,204,419.0	80.40%	80.40%	169.00%
ТХБанк	0.05%				
		12,249,190.0		190.43%	3355.90%
		10,127,400.0	96.84%	97.00%	46.50%

\* - Сүүлийн 6 сар банкны системийн нийт активын 5 хувиас дээш хувийг бүрдүүлж байгаа банкуудад нэмэлт өөрийн хөрөнгө тооцно.

дунд, жижиг гэж ангилсан бөгөөд том банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж 17.9 хувь, дунд банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж 17.0 хувь, жижиг банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж 62.0 хувьтай байна.

Дээрхээс харахад өөрийн хөрөнгийн хүрэлцээ жижиг банкуудын хувьд том болон дунд банкуудаас өндөр байна. Энэ нь жижиг банкуудын хувьд бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө бага, хувь нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгө өндөр байдаг болохыг харуулж байна.

Хүснэгт 4. Арилжааны банкуудын өөрийн хөрөнгөөрөө системд эзлэх хувь


	Активын хэмжээ (мян.төг)	Банкны системд эзлэх хувь		Өөрийн хөрөнгө	Банкны системд эзлэх хувь	
ХХБ	5,482,283,922.0	26.6%	67.8%	670,757,230	27.6%	76.1%
ХААН банк	5,068,765,615.0	24.6%		766,352,574	31.5%	
Голомт банк	3,421,498,283.0	16.6%		413,637,158	17.0%	
Төрийн банк	1,948,541,053.0	9.5%	28.4%	162,640,505	6.7%	19.3%
Хас банк	1,728,197,689.6	8.4%		149,970,632	6.2%	
УБХБанк	1,338,479,663.0	6.5%		86,109,768	3.5%	
Капитал банк	841,806,868.3	4.1%		72,170,973	3.0%	
Чингис хаан банк	232,408,000.0	1.1%		19,942,000	0.8%	
ҮХОБанк	208,315,387.1	1.0%	3.7%	22,610,479	0.9%	4.6%
Капитрон банк	174,518,813.0	0.8%		16,887,940	0.7%	
Ариг банк	89,733,784.0	0.4%		12,941,273	0.5%	
Богд банк	39,204,419.0	0.2%		17,490,844	0.7%	
Кредит банк	12,249,190.0	0.1%		12,057,121	0.5%	
ТХБанк	10,127,400.0	0.05%		10,000,425	0.4%	

Эх сурвалж: Арилжааны банкуудын 2015 оны III улирлын санхүүгийн тайлан

Аливаа байгууллагын хувьд хөрөнгөө санхүүжүүлэх эх үүсвэр хэрэгтэй байдаг бөгөөд арилжааны банкуудын хувьд эх үүсвэр нь голчлон бусдаас татсан харилцах хадгаламж, өр төлбөр болон

өөрийн хөрөнгө байдаг. Тэгвэл манай улсын арилжааны банкуудын эх үүсвэр болон өөрийн хөрөнгийн харьцааг харуулвал дараах байдалтай байна.

Зураг 5. Арилжааны банкуудын өр төлбөр, өөрийн хөрөнгийн харьцаа



Эх сурвалж: Арилжааны банкуудын 2015 оны III улирлын санхүүгийн тайлан

Дээрхээс харахад жижиг банкуудын хувьд эх үүсвэрт эзлэх өөрийн хөрөнгийн хэмжээ дунджаар 40.8 хувь, дунд банкуудын хувьд 8.0 хувь, том банкуудын хувьд 13.1 хувьтай байна. Жижиг банкуудаас Кредит болон Тээвэр хөгжлийн банкуудын өөрийн хөрөнгө нь нийт эх үүсвэрийнхээ 98 хувийг бүрдүүлж байна. Банкууд өөрсдийн үйл ажиллагааны чиглэл, бүтцээсээ хамааран өр төлбөр, өөрийн хөрөнгийн харьцаа өөр байгаа бөгөөд ялангуяа жижиг банкуудын

хувьд том, дунд банкуудаа бодоход эх үүсвэрт эзлэх өөрийн хөрөнгийн хэмжээ харьцангуй их байна.

Хоёр. Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх боломжит хувилбарууд

Банкуудын өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх эх үүсвэрүүдийн талаар нэгдүгээр бүлэгт авч үзсэнээр онолын түвшинд дараах арга замууд байдаг. Үүнд:

Хүснэгт 5. Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх эх үүсвэрийн аргууд

№	Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх аргууд	Давуу тал	Сул тал	Бүтэц
1	Хуримтлагдсан ашиг	<ul style="list-style-type: none"> <li>- Бусад боломжуудтай харьцуулахад зардал багатай</li> <li>- Зах зээлээс хамаардаггүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн хөрөнгө ашгаас шууд хамааралтай болох</li> <li>- Өөрийн хөрөнгө бүтцийн хувьд жижиг болох</li> <li>- Татвар оногдож, хүүний өөрчлөлтөнд амархан өртдөг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Тайлант үеийн ашиг (алдагдал)</li> <li>- Өмнөх үеийн ашиг (алдагдал)</li> <li>- Нөөцийн сан</li> <li>- Нийгмийн хөгжлийн сан</li> </ul>
2	Хувьцаат капитал	<ul style="list-style-type: none"> <li>- Цэвэр ашгийн хэмжээ нэмэгдэх</li> <li>- Дүрмийн сангийн хэмжээ нэмэгдэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хувь нийлүүлэгчдийн саналыг хуваах</li> <li>- Гаргалтын зардал өндөр</li> <li>- Ногдол ашгийн зардал өндөр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Энгийн хувьцаа</li> <li>- Давуу эрхийн хувьцаа</li> <li>- Халаасны хувьцаа</li> </ul>
3	Хоёрдогч өглөг	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх</li> <li>- Хугацаа нь дуусахад хувьцаа болж хөрвөх чадвартай</li> <li>- Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийг хуваахгүй</li> <li>- Гадны хөрөнгө оруулалттай том банкууд ихэвчлэн хэрэгжүүлдэг</li> <li>- Татварт өртдөггүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Зардал ихтэй</li> <li>- Өр үүсгэдэг</li> </ul>	
4	Хөрөнгөө борлуулах, эсвэл түрээслэх	Банк активаа зарах ба түрээслүүлснээр бэлэн мөнгө олох ба түүнийгээ хөрөнгө оруулалт хийх, зээлдүүлэх, мөн хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх зэрэгт ашигладаг.		
5	Банкуудын нэгдэлт, нийлэлт	Сүүлийн жилүүдэд олон улсад ялангуяа АНУ-д банкууд хоорондоо нэгдэх, нэг нь нөгөөгөө худалдаж авах замаар өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж, нэмэлт шаардлагууд болон тогтвортой, найдвартай байдлаа хангах нь их болсон. Өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх зорилгоор хоорондоо нэгдсэн олон улсын банкуудын туршлагаас дурдвал Москвагийн Олон Улсын Банк (МОУБ) болон Австралийн Кредитансталд Банкууд (АКБ) хоорондоо нэгдсэн явдал юм. ОХУ-ын банк Австралийн банкинд хувьцаат капиталгаа санхүүжүүлэх санал болгосноор Австралийн банк болон ОХУ-ын банкны ТУЗ нэгдэх шийдвэрийг гаргаж МОУБ-ны шинээр гаргасан хувьцааг АКБ худалдаж авах замаар хоорондоо нэгдсэн. ( <a href="http://www.ebrd.com/cs/Satellite?c=Content&amp;cid=1395243682378&amp;pagename=EBRD%2FContent%2FContentLayout">http://www.ebrd.com/cs/Satellite?c=Content&amp;cid=1395243682378&amp;pagename=EBRD%2FContent%2FContentLayout</a> )		

Эх сурвалж: Х.Халиун, 2014

Эдгээр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх аргачлалууд нь өөрсдийн гэсэн давуу, сул талуудтай бөгөөд хэрэгжүүлэх банкууддаа тэдгээрийн үйл ажиллагаа болон бусад нөхцөлөөс шалтгаалан өөр өөрсдийн гэсэн боломжийг олгож байдаг. Одоогийн байдлаар Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж буй арилжааны банкууд өөрийн хөрөнгөө энгийн хувьцаа болон хуримтлагдсан ашгаараа голчлон нэмэгдүүлж байгаа бөгөөд энэ нь банкны өөрийн хөрөнгийн бүтцийг олон төрлөөр

бүрдүүлэх боломжийг хязгаарладаг байна.

**Өөрийн хөрөнгийг хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлэх боломж**


Хуримтлагдсан ашгийг тайлант үеийн ашиг (алдагдал), өмнөх үеийн ашиг (алдагдал), нөөцийн сан, нийгмийн хөгжлийн сан бүрдүүлдэг. Монголын банкуудын өөрийн хөрөнгөө хуримтлагдсан ашгаараа бүрдүүлж буй байдлыг судалж үзэхэд дараах байдалтай байна.

**Зураг 6. Том банкуудын өөрийн хөрөнгө дэх хуримтлагдсан ашгийн байдал**




Эх сурвалж: Арилжааны банкуудын 2015 оны III улирлын санхүүгийн тайлан

**Зураг 7. Дунд банкуудын өөрийн хөрөнгө дэх хуримтлагдсан ашгийн байдал**



Эх сурвалж: Арилжааны банкуудын 2015 оны III улирлын санхүүгийн тайлан

**Зураг 8. Жижиг банкуудын өөрийн хөрөнгө дэх хуримтлагдсан ашгийн байдал**



Эх сурвалж: Арилжааны банкуудын 2015 оны III улирлын санхүүгийн тайлан



Дээрхээс харахад үйл ажиллагаагаа явуулж буй 3 том банкны хувьд хуримтлагдсан ашиг нь ХААН банкны нийт өөрийн хөрөнгийн 65.8 хувийг, Худалдаа хөгжлийн банкны нийт өөрийн хөрөнгийн 66.8 хувийг, Голомт банкны нийт өөрийн хөрөнгийн 57.6 хувийг бүрдүүлж байна. Том 3 банкуудын хувьд хуримтлагдсан ашгийг бүрдүүлж буй хөрөнгөөс өмнөх үеийн ашиг нь дийлэнх хэсгийг эзэлж байгаа бөгөөд Худалдаа хөгжлийн банкны нөөцийн сан 0.1 хувь, Голомт банкны нөөцийн сан 0.06 хувийг бүрдүүлж байна. Эдгээр банкуудын хувьд сүүлийн 3 улирал хуримтлагдсан ашиг нь тогтмол нэмэгдсэн байна. Дунд банкуудаас Хас банк болон Улаанбаатар хотын банкуудын өөрийн хөрөнгийн дийлэнх хувийг буюу 63 хувийг хуримтлагдсан ашиг бүрдүүлж байгаа бол Төрийн банкны өөрийн хөрөнгийн 23.1 хувийг, Капитал банкны өөрийн хөрөнгийн 22 хувийг хуримтлагдсан ашиг тус тус бүрдүүлж байна. Активын хэмжээгээр дунд ангилалд орж байгаа банкуудын хувьд мөн өмнөх үеийн ашиг нь хуримтлагдсан ашгийн дийлэнхи хэсгийг бүрдүүлж байна. Хуримтлагдсан ашигт эзлэх нөөцийн сангийн хувьд Төрийн банк 1.8 хувь, Хас банк 11.1 хувь, Капитал банк 5.8 хувийг тус тус бүрдүүлж байна. Харин сангуудын хувьд Төрийн банк 2.5 хувь, Капитал банк 0.3 хувийг бүрдүүлж байна. Эдгээр банкуудын тайлант үеийн ашиг нь сүүлийн улиралд нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Активын хэмжээгээр жижиг банкны ангилалд орж буй банкуудын хувьд Богд банкнаас бусад 6 банкны хуримтлагдсан ашиг хасах үлдэгдэлтэй байна. Үүнд банкуудын өмнөх үеийн ашиг 1.3-20.5 хүртэлх алдагдалтай ажилласан нь ихээхэн нөлөөлсөн. Тайлант үеийн ашигийн хувьд Капитрон банк, Ариг банк, Тээвэр хөгжлийн банкууд алдагдалтай

ажилласан байна.

Эдгээрээс харахад Монголд үйл ажиллагаа явуулж буй банкууд өөрийн хөрөнгийнхөө 5-67 хүртэлх хувийг хуримтлагдсан ашгаараа бүрдүүлж байна. Эдгээр банкуудаас цаашид өөрийн хөрөнгөө хуримтлагдсан ашгаараа нэмэгдүүлэх боломжтой банкууд ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Төрийн банк, Хас банк, Улаанбаатар хотын банк болон Капитал банкууд байна. Харин активын хэмжээгээрээ жижиг банкны ангилалд орж байгаа банкуудын хувьд өөрийн хөрөнгөө хуримтлагдсан ашгаараа нэмэгдүүлэх боломж маш бага байна. Учир нь Богд банкнаас бусад банкуудын хуримтлагдсан ашиг 2009-2014 оноос эхлэн тогтмол хасах үлдэгдэлтэй байсан бөгөөд 2015 оны эхний улирлаас эхлэн ашигтай ажиллаж эхэлсэн ч хуримтлагдсан ашгийн алдагдлыг нөхөхөд 1.3-20.5 тэрбум төгрөг хүртэлх ашигтай ажиллах шаардлагатай байна. Гэвч банкууд ашигтай ажиллаж байгаа ч энэ нь дундажаар 1 тэрбум хүртэлх төгрөг байгаа юм.

Хуримтлагдсан ашгийг бүрдүүлэгч нөөцийн сан, нийгмийн хөгжлийн сангуудын хувьд нөөцийн сан нь тодорхой алдагдалд зориулсан сан байдаг учир тухайн зориулалтынхаа дагуу л ашиглагддаг хөрөнгө юм. Харин нийгмийн хөгжлийн сангийн хувьд хуримтлагдсан ашгаас хуваарилалт хийж энэхүү санг үүсгэдэг, мөн байгууллагын нийгмийн хариуцлагад ашиглагддаг сан юм. Энэхүү 2 сан нь хуримтлагдсан ашгийн 0.1-11.1 хувийг л эзэлж байгаа юм. Банкууд бүгд энэхүү 2 санг нэмэгдүүлж болох ч эдгээр сангуудыг нэмэгдүүлснээр өөрийн хөрөнгийн шаардлагыг хангах болон дүрмийн сангийн шаардлагыг хангахад ихээхэн хувь нэмэр оруулах боломж бага юм.

Хуримтлагдсан ашгаараа өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх боломжтой банкуудаас хуримтлагдсан ашиг маш өндөр байгаа ХААН банк, Худалдаа хөгжлийн банкууд дүрмийн сангийн нэмэлт шаардлага болох 50 тэрбум төгрөгийг хангахын тулд хуримтлагдсан ашгаасаа энгийн хувьцаа болон давуу эрхтэй хувьцаанд хөрөнгө оруулж дүрмийн сангийн шаардлагыг хангах боломжтой байгаа юм.

*Өөрийн хөрөнгийг хувьцаагаар нэмэгдүүлэх боломж*

Энгийн хувьцааг зах зээл дээрх томоохон


банкууд гаргах сонирхолтой байдаг бөгөөд энэ нь томоохон банкуудын хувьд дийлэнх хэсэг нь гадны хөрөнгө оруулалттай, олон хувьцаа эзэмшигчтэй байдагтай холбоотой юм. Харин жижиг банкуудын хувьд цөөн тооны хувьцаа эзэмшигчтэй байдаг бөгөөд хувьцаа эзэмшигчид нь нэмж хувьцаа гаргах сонирхолгүй байдаг байна (Х.Халиун, 2014). Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж буй банкуудын хувьцаат капиталыг судалж үзэхэд 2015 оны III улирлын байдлаар дараах байдалтай байна.

Хүснэгт 6. Банкуудын хувьцаат капиталын бүтэц ба өөрийн хөрөнгөд эзлэх хувь

	Хувьцаат капитал	Энгийн хувьцаа	Давуу эрхтэй хувьцаа	Халаасны хувьцаа	Нийт ӨХ-д эзлэх хувь
ХААН банк	100%	753%	0%	-653%	0.6%
ХХБанк	100%	100%	0%	0%	2.3%
Голомт банк	100%	51%	49%	0%	12.6%
Төрийн банк	100%	100%	0%	0%	69.5%
Хас банк	100%	100%	0%	0%	13.6%
УБХБанк	100%	100%	0%	0%	18.6%
Капитал банк	100%	100%	0%	0%	45.7%
ҮХОБанк	100%	100%	0%	0%	72.4%
Чингис хаан банк	100%	100%	0%	0%	197.4%
Богд банк	100%	100%	0%	0%	94.8%
Капитрон банк	100%	100%	0%	0%	213.2%
Ариг банк	100%	100%	0%	0%	125.9%
Кредит банк	100%	100%	0%	0%	133.4%
Тээвэр хөгжлийн банк	100%	100%	0%	0%	160.0%

Эх сурвалж: Арилжааны банкуудын 2015 оны III улирлын санхүүгийн тайлан

Зураг 9. Банкуудын хувьцаат капиталын хэмжээ



Эх сурвалж: Арилжааны банкуудын 2015 оны III улирлын санхүүгийн тайлан

2015 оны III улирлын байдлаар банкуудын өөрийн хөрөнгөд эзлэх хувьцаат капиталын хэмжээ том банкуудых дунджаар 5.2 хувь, дунд банкуудых дунджаар 36.8 хувь, жижиг банкуудых дунджаар 142.4 хувьтай байна. Голомт банкнаас бусад банкууд бүгд хувьцаат капиталаа энгийн хувьцаагаар бүрдүүлсэн байгаа бөгөөд Голомт банкны хувьд хувьцаат капиталынх нь 49 хувийг давуу эрхтэй хувьцаа бүрдүүлж байгаа юм. Голомт банк, Төрийн банкнаас бусад банкуудын хувьцаат капитал 16-39 тэрбум төгрөг хүртэл хэмжээтэй байна. Энэ нь Монголын арилжааны банкууд дүрмийн сангийн шаардлагын доод хэмжээ болох 50 тэрбум төгрөгийг хангахад 11-34 тэрбум төгрөгийн нэмэлт энгийн хувьцаа болон давуу эрхийн хувьцаа шаардлагатай байгаа юм. Банкууд өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж хувьцаа гаргахдаа ихэвчлэн дотооддоо нэмж гаргадаг бөгөөд Анод банк 2008 онд, Зоос банк 2006 онд анх хувьцаагаа нээлттэй арилжаалж эхэлсэн боловч удалгүй үйл ажиллагаагаа зогсоосон. Одоо үйл ажиллагаагаа явуулж буй банкууд хувьцаагаа дотооддоо нэмж гаргахдаа өөр нэгэн боломж болох нийтэд хувьцаагаа арилжаалж өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх боломжийг авч үзье.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2009.02.12-ны өдөр шинэчлэн баталсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай” журмын II бүлэгт заасан шаардлагыг анх удаа хувьцаагаа нийтэд санал болгож буй бүх компаниудад тавьдаг бөгөөд нийтэд санал болгон хувьцаа гаргах арилжааны банк нь энэхүү хуулийн 2.3 дахь хэсэгт заасан шаардлагуудаас гадна дараах шаардлагыг хангасан байхыг заасан байдаг. Үүнд:

1. Нийтэд санал болгон хувьцаа гаргах асуудлаар Монголбанкнаас зөвшөөрөл

авсан байх,

2. Сүүлийн 8 улирал дараалан Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг хангаж ажилласан, энэ тухай Монголбанк тодорхойлолт гаргасан байх,
3. Олон улсад хүлээн зөвшөөрсөн банкны сайн засаглалын зарчим, монголын компанийн засаглалын кодексийн зарчимд нийцсэн дотоод журмуудаа боловсруулж баталсан байх.

Нийтэд санал болгон хувьцаа гаргах арилжааны банк нь нэмэлт шаардлагын дагуу Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг сүүлийн 8 улирал хангаж ажилласан байх ёстой бөгөөд энэхүү шаардлага нь:

- 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа,
- Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа,
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар,
- Нэг зээлдэгчид олгосон зээл, өөрийн хөрөнгийн харьцаа,
- Холбогдогч нэг этгээдэд олгосон зээл, өөрийн хөрөнгийн харьцаа,
- Холбогдогч этгээдэд олгосон нийт зээл, өөрийн хөрөнгийн харьцаа гэсэн шаардлагууд юм.

Өөрийн хөрөнгийн өгөөжийн 5 хувийг хангасан банкуудын Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг хангасан байдлыг судалж үзэхэд (2013 оны IV улирлаас 2015 оны III улирал) Улаанбаатар хотын банкнаас бусад банкууд дээрх үзүүлэлтүүдийг хангаж байна. Харин Улаанбаатар хотын банк Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүдийг хангаж ажиллаж байгаа эсэх мэдээллээ санхүүгийн тайлан болон цахим хуудсандаа мэдээллээгүй байсан.

Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд банкууд дотооддоо хувьцаа эзэмшигчиддээ нэмж хувьцаа гаргадаг бөгөөд Монголд үйл ажиллагаагаа явуулж буй банкуудаас одоогоор нийтэд санал болгож хувьцаа гаргаж арилжаалж буй банк байхгүй юм. Харин одоо үйл ажиллагаагаа явуулж буй 14 банкнаас шинээр хувьцаа гаргаж, өөрийн хөрөнгө, дүрмийн сангаа нэмэгдүүлэх боломжтой банкууд нь ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хас банкууд байна. Төрийн банк нь 100% төрийн өмчит (хувьцаа эзэмшигчид нь Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпораци) банк учраас нийтэд хувьцаа санал гаргах боломжийн судалгаанд оруулаагүй болно. Мөн Богд банк нь үйл ажиллагаагаа явуулаад 5 жилийн хугацаа хүрээгүй учраас одоогийн байдлаар хувьцаагаа нийтэд санал болгон арилжих боломжгүй байгаа юм.

*Өөрийн хөрөнгийг хоёрдогч өглөг гарган нэмэгдүүлэх боломж*

Монголын банкуудын хувьд нэг банк нь цөөн тооны хүмүүсийн эзэмшилд байдаг учир хувьцааг хуваахгүйгээр, хуримтлагдсан ашгаар өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх сонирхолтой байдаг байна. Өөрийн хөрөнгийг хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлэх боломжийн судалгаанд активын хэмжээгээрээ жижиг банкны ангилалд орж байгаа банкууд сүүлийн жилүүдэд хуримтлагдсан ашгууд нь их хэмжээний хасах үлдэгдэлтэй байсан учир хуримтлагдсан ашгаараа өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх боломж бага байсан. Харин ийм төрлийн банкуудын өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх боломж нь хоёрдогч өглөг хэлбэрээр байх боломжтой юм. Хоёрдогч өглөг гэж гэрээнд заасан хугацаа дууссаны эцэст хөрөнгө оруулагчдын хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаагаар солих

бөгөөд энэ талаар холбогдох гэрээнд тодорхой заасан байх өрийн бичгийг хэлнэ (Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам, 2010). Хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх нь зардал ихтэй ч урт хугацааны тогтвортой хөрөнгө бөгөөд хугацааны эцэст хувьцаа руу хөрвөдөг, татварын зардалыг бууруулах гэх мэт банкинд хэд хэдэн давуу талыг бий болгодог. Манай улсын хувьд анх 2007 онд Худалдаа хөгжлийн банк олон улсын санхүүгийн зах зээлд 75 сая ам.долларын бонд гаргаж 2010 оны I сард бүрэн төлж дууссан бол ХААН банк 2013 онд Олон Улсын Санхүүгийн Корпорациас 111 сая ам.долларын эх үүсвэр татаж, үүнийхээ 40 сая ам.долларыг хоёрдогч өглөгийг нэмэгдүүлэхэд зориулсан гэх мэт туршлагаудтай. 2015 оны III улирлын байдлаар ХААН банк 223.7 тэрбум, Голомт банк 69.9 тэрбум, Улаанбаатар хотын банк 4.0 тэрбум, Капитал банк 20 тэрбум төгрөг хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгөө бүрдүүлсэн байна.

2010 онд батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих” журмын 2.6.3-т зааснаар банкны хоёрдогч өглөг нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтрэхгүй гэж заасан байдаг. Энэхүү шаардлагын дагуу 14 банкны хувьд хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгийг хэдий хэмжээгээр нэмэгдүүлэх боломжтойг судалж үзэхэд том банкны ангилалд орж буй 3 банкууд дунджаар 224.4 тэрбум, дунд банкны ангилалд орж буй 4 банк дунджаар 52.8 тэрбум, жижиг банкны ангилалд орж буй үлдсэн банкууд дунджаар 7.3 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөг гаргах боломжтой байна. Банк тус бүрийн үзүүлэлтийг Хүснэгт 7-д харуулав.

## Хүснэгт 7. Банкуудын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хэмжээ болон гаргах боломжтой хоёрдогч өглөгийн хэмжээ

Банкууд	Энгийн хувьцаа	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хандивын капитал	Тайлант үеийн ашиг (алдагдал)	Өмнөх үеийн ашиг (алдагдал)	Нөөцийн сан	I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүн	Боломжит хоёрдогч өглөгийн хэмжээ
ХААН банк	32,995,030.0	-28,613,933.9	14,140,923.0	0.0	99,112,827.4	404,938,251.9	0.0	522,573,098.4	261,286,549.2
ХХБанк	16,525,280.0	0.0	19,272,456.1	0.0	73,780,253.4	403,491,850.7	494,515.6	513,564,355.8	256,782,177.9
Голомт банк	26,367,593.0	0.0	45,407,071.6	0.0	15,523,567.1	222,670,664.9	150,571.6	310,119,468.2	155,059,734.1
Төрийн банк	113,000,000.0	0.0	0.0	0.0	11,128,213.6	24,745,149.7	693,668.8	149,567,032.1	74,783,516.1
Хас банк	20,353,656.0	0.0	34,989,097.3	0.0	16,099,880.1	67,966,631.4	10,531,367.3	149,940,632.1	74,970,316.1
УБХБанк	16,000,000.0	0.0	0.0	0.0	10,140,712.7	44,627,104.9	0.0	70,767,817.6	35,383,908.8
Капитал банк	33,000,000.0	0.0	3,418,106.5	0.0	2,287,049.8	12,508,255.4	907,861.4	52,121,273.1	26,060,636.6
ҮХОБанк	16,373,581.2	0.0	0.0	0.0	349,143.2	-1,333,370.0	0.0	15,389,354.4	7,694,677.2
Чингис хаан банк	39,373,246.0	0.0	0.1	0.0	1,108,822.3	-20,539,415.3	0.0	19,942,653.1	9,971,326.6
Богд банк	16,576,050.0	0.0	0.0	0.0	841,198.7	73,594.9	0.0	17,490,843.6	8,745,421.8
Капитрон банк	36,000,548.0	0.0	0.0	0.0	-19,846,406.1	-2,095,208.9	0.0	14,058,933.0	7,029,466.5
Ариг банк	16,290,000.0	0.0	0.0	0.0	-1,663,640.7	-1,688,126.7	3,041.2	12,941,273.8	6,470,636.9
Кредит банк	16,090,013.2	0.0	0.0	0.0	67,843.6	-4,100,799.4	0.0	12,057,057.4	6,028,528.7
Тээвэр хөгжлийн банк	16,000,000.0	0.0	0.0	0.0	-394,918.5	-5,648,956.6	27,922.0	9,984,046.9	4,992,023.5

Эх сурвалж: Арлжааны банкуудын 2015 оны III улирлын санхүүгийн тайлан

*Арилжааны банкууд нэгдэх замаар  
өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх боломж*

Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум төгрөг байхаар шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор дүрмийн сангаа нэмэгдүүлэх шаардлага банк бүрт тулгараад байгаа юм. Дүрмийн сангийн хэмжээг хувьцааны хэмжээгээр тооцдог бөгөөд одоогийн байдлаар 50 тэрбум төгрөгийн дүрмийн санг хангасан банк (Зураг 9-д харуулсанчлан) Төрийн банк болон Голомт банкууд байгаа юм. Дүрмийн сангийн доод хэмжээг хангаагүй байгаа үлдсэн банкуудын хувьд дүрмийн санг нэмэгдүүлэхэд энгийн хувьцаа, давуу эрхтэй хувьцаа гаргах шаардлага гарч байгаа бөгөөд харин өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх хувьцааны эх үүсвэр нь гаргалтын зардал өндөр, хувь нийлүүлэгчдийн хүртэх өгөөж буурах зэрэг сул талуудтай байдгаас гадна ялангуяа цөөн тооны хувьцаа эзэмшигчтэй жижиг банкууд банкны эзэмшигчдийг нэмэгдүүлэх сонирхолгүй байдаг. Мөн өөрийн хөрөнгийг хувьцаагаар нэмэгдүүлэх боломжийн судалгаанд ХААН банк, Худалдаа Хөгжлийн банк, Голомт банк, Хас банк, Улаанбаатар хотын банкуудаас бусад банкууд нийтэд санал болгон хувьцаагаа арилжих боломжгүй байгаа юм. Тиймээс бусад банкуудын хувьд хоорондоо болон бусад том, дунд банкуудтай нэгдэж, нийлэх замаар хувьцаат капиталаа нэмэгдүүлэх боломжтой юм.

Дүгнэлт

Манай улсын хувьд дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад банкны хоёр шатлалт систем үүсч хөгжөөд төдийлөн удаагүй байгаа хэдий ч банкны салбар нь Монгол улсын санхүүгийн зах зээлийн 96 хувийг бүрдүүлж, олон улсын стандартад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулахаар ажиллаж байна. Банкинд тавигдах шаардлага манай улсад төдийгүй олон улсад ч нэмэгдсээр байна. Банкны үйл ажиллагаа өргөжихийн зэрэгцээ манай улсын банкууд олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж, үүнийгээ дагаад олон улсад тавигдаж буй стандарт, шаардлагуудад хүрч ажиллах хэрэгцээ бий болж байгаа юм. Банкны найдвартай, тогтвортой байдлыг хангадаг хамгийн гол хөрөнгө нь банкны өөрийн хөрөнгө байдаг. Тиймээс 2013 онд олон улсын Базелийн хорооны зөвлөмжөөр банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шаардлагыг нэмэгдүүлсэн бол 2015.04.01-ний өдөр Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум төгрөг байхаар шинэчлэн тогтоожээ. Энэхүү шаардлагын дагуу банкуудад өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлага бий болов.

Банкууд өөрийн хөрөнгөө хуримтлагдсан ашгаар, хувьцаат капиталаар, хоёрдогч өглөгөөр мөн хоорондоо нэгдэж, нийлэх замаар нэмэгдүүлэх боломжтой байдаг бөгөөд Монгол улсын арилжааны банкуудын өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх боломжийг судалж үзэхэд дараах байдалтай байна.

- Өөрийн хөрөнгөө хуримтлагдсан ашгаараа нэмэгдүүлэх боломжтой ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Төрийн банк, Хас банк,

Улаанбаатар хотын банк болон Капитал банкууд байна.

- Нээлттэй зах зээл дээр шинээр хувьцаа гарган өөрийн хөрөнгө, дүрмийн сангаа нэмэгдүүлэх боломжтой ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хас банк, Улаанбаатар хотын банкууд байна.
- Монголбанкны зохистой харьцаа үзүүлэлтийн шаардлагыг үндэслэж хоёрдогч өглөг хэлбэрээр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэхэд том банкууд дунджаар 224.4 тэрбум, дунд банкууд дунджаар 52.8 тэрбум, жижиг банкууд дунджаар 7.3 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөг гаргах боломжтой байна. (Банкуудын ангиллыг Хүснэгт 3-с харна уу)
- Дэлхийн улс орны банкууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэхэд хоорондоо нэгдэж, нийлэх аргыг ихээхэн ашигладаг болсон. Манай улсын хувьд жижиг банкууд хоорондоо нэгдэх, эсвэл том болон дунд банкуудтай нийлэх нь жижиг банкуудын хувьд үр ашгийг нэмэгдүүлэх хандлагатай байна.

Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж буй банкуудаас активын хэмжээгээрээ том ангилалд орж байгаа банкууд хуримтлагдсан ашиг, хувьцаа болон хоёрдогч өглөгийг ашиглан өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх боломжтой байгаа бол дунд банкууд хуримтлагдсан ашгаараа эсвэл хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх боломжтой байгаа юм. Харин жижиг банкуудын хувьд сүүлийн жилүүдэд алдагдалтай ажиллаж, хуримтлагдсан ашиг нь хасах үлдэгдэлтэй болсон. Тиймээс жижиг банкууд болон дунд банкны ангилалд орж буй зарим банкууд өөрийн хөрөнгөө нээлттэй зах зээл дээр шинээр хувьцаа гарган нэмэгдүүлэх боломжгүй

байгаа юм. Харин эдгээр банкууд нь хоорондоо эсвэл бусад том болон дунд банкуудтай нэгдэж, нийлснээр зах зээлд эзлэх байр суурь болон өөрийн хөрөнгийн найдвартай байдал нь илүү нэмэгдэх юм.

#### Санал

1. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор банкууд хувьцаат капиталаа нэмэгдүүлэх шаардлагатай болсон. Үүнтэй холбоотойгоор банкууд нээлттэй зах зээл дээр шинээр хувьцаа гаргахад шаардлагатай эрх зүйн нөхцөл болон хяналт шалгалтыг сайжруулах хэрэгтэй юм.
2. Өөрийн хөрөнгөө хуримтлагдсан ашгаараа нэмэгдүүлэх сонирхолтой байгаа банкуудын хувьд энэ арга нь бусад боломжуудтай харьцуулахад зардал багатай, зах зээлээс хамаардаггүй давуу талтай юм.
3. Банкууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэхэд өөрийн хөрөнгийн өгөөж сүүлийн 5 жилд 5 хувиас дээш байх шаардлагыг тавьдаг. Жижиг банкуудын хувьд энэхүү шаардлагыг хангаж чадахгүй байгаа бөгөөд өөрийн хөрөнгөө хувьцаат капиталаар нэмэгдүүлэх сонирхолтой байгаа банкууд активын чанарыг сайжруулах, ашгаа нэмэгдүүлэх гэх мэт өөрийн хөрөнгийн өгөөжөө нэмэгдүүлэх арга хэмжээг авах хэрэгтэй байна.
4. Хоёрдогч өглөг хэлбэрээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх нь банкуудын хувьд хугацаа нь дуусахад хувьцаа болж хөрвөх чадвартай, хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийг хуваадаггүй, гадны хөрөнгө оруулалттай том банкууд ихэвчлэн хэрэгжүүлдэг, татварт өртдөггүй гэх мэт давуу талуудыг бий болгодог.

5. Банкууд нэгдэж, нийлснээр зах зээлд эзлэх байр суурь болон өөрийн хөрөнгийн найдвартай, тогтвортой байдал нэмэгдэх бөгөөд жижиг банкуудын хувьд бусад банктэй нэгдэх нь илүү үр ашгийг авчрахаар байна. Ялангуяа ашигт ажиллагаа нь буурч байгаа, нээлттэй зах зээлд шинээр хувьцаа гаргах боломжгүй банкуудын хувьд энэ арга нь илүү тохиромжтой.

#### Ашигласан материал

1. Dang, U. (2011). The CAMEL Rating System in Banking Supervision: A Case Study
2. Basel Committee on Banking Supervision (2006). International Convergence of Capital Measurement and Capital Standards
3. Basel Committee on Banking Supervision (2011). Basel III Handbook, Accenture
4. Basel Committee on Banking Supervision (2015). A Brief History of the Basel Committee
5. Basel Committee on Banking Supervision (2015). Basel III Phase-in Arrangements
6. Berger, A. N., DeYoung, R., Flannery, M. J., Lee, D., Oztekin, O. (2008). How Do Large Banking Organizations Manage Their Capital Ratios?, *Journal of Financial Services Research*, 34(2-3), 123-149
7. Majluf, N. S., Myers, S. C. (1984). Corporate Financing and Investment Decisions When Firms Have Information That Investors Do Not Have, *Journal of Financial Economics*, 13(2), 187-221

#### Ном, сурах бичиг

8. Ганзориг, А. (2014). Эрсдэлийн удирдлага
9. Мөнхзаяа, Б. (2013). Санхүүгийн байгууллагын эрсдэлийн менежмент
10. Мятагмаа, Б. (2013). Арилжааны банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх арга замууд
11. Насанбаяр, Б. (2004). Арилжааны банкны үйл ажиллагааны үндэс
12. Оюун, Л. (2005). Арилжааны банкны дампуурал, Монголын төлбөрийн чадваргүй болсон арилжааны банкууд
13. Оюунцацрал, З. (2003). Банкны удирдлага
14. Оюунцацрал, З. (2008). Санхүүгийн байгууллагын эрсдэлийн удирдлага
15. Халиун, Х. (2014). Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх боломж

#### Хууль, дүрэм, журам

16. Монголбанк (2001). Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь иж бүрэн шалгалт хийж үнэлгээ, дүгнэлт өгөх журам
17. Банкны тухай хууль, 2010



18. Монголбанк (2010). Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам. (2010).

*Бусад*

19. Монголбанк (2010-2015.III). Банкуудын нэгдсэн тайлан
20. Монголбанк (2015). Монгол улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан

*Цахим эх сурвалж*

21. [www.amigobulls.com](http://www.amigobulls.com)
22. [www.bis.org](http://www.bis.org)
23. [www.ebrd.com/cs/Satellite?c=Content&cid=1395243682378&pagename=EBRD%2FContent%2FContentLayout](http://www.ebrd.com/cs/Satellite?c=Content&cid=1395243682378&pagename=EBRD%2FContent%2FContentLayout)